



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 1/316

Ховд


Г Дараа тооцохоор санхүүжилт олгох тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны "Аймгийн 2022 оны төсөв батлах тухай" 5/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Төрийн аудитын газрын 2022 оны 05 дугаар сарын "Хүсэлт уламжлах тухай" 267 дугаар албан бичгээр ирүүлсэн Төрийн аудитын газрын аудитор Д.Эрдэнэцэцэгийг Улаанбаатар хотод яаралтай эмчилгээ хийлгэхэд шаардлагатай байгаа 10,000,000 төгрөгийн төлбөрийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжүүлэх хүсэлтийг үндэслэн Төрийн аудитын газарт дараа тооцоогоор санхүүгийн дэмжлэгт 10,000,000 төгрөг (арван сая)-ийг түр олгосугай.

2. Тус санхүүгийн дэмжлэгт олгох нийт 10,000,000 төгрөгийг аймгийн техник хяналтын зардлын данснаас дараа тооцоогоор зохицуулж санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), Санхүү, төрийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.

3. Аймгийн техник хяналтын зардлаас дараа тооцоогоор санхүүжүүлсэн 10,000,000 төгрөгийг аймгийн Төрийн аудитын байгууллагаас 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор тооцоо хийж барагдуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01^{ah} 1698